

**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН  
2018 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

<b>Агуулга</b>	
1	Аудитын гэрчилгээ.....2
2	Аудитын тайлан.....4
2.1.	Оршил .....4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....7
2.8.1	Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....7
2.8.2	Төсвийн төвлөрүүлэн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар.....8
2.8.3	Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар.....9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..... 10
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ..... 10
2.11.	Шилэн дансны мэдээлэл ..... 11
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ..... 11
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ..... 11
3	Менежментийн захидал.....12
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан.....14
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан..... 14
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан..... 15
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 16
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан..... 17
4.5	Аудитын явцад илэрсэн, зөрчлийн жагсаалт.....17

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨААН	Төрийн өмчит аж ахуйн нэгж



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГА Л.БЯМБАСҮРЭН  
ТАНАА

2019. 03. 25 № 01/605  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Иргэний нисэхийн ерөнхий газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ОЮУНБИЛЭГ

## **2 Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Л.Бямбасүрэн Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийлээ.

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 25-аас 2019 оны 3 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Сэржмядаг, Г.Мөнхчимэг нар хэрэгжүүлэв. Иргэний нисэхийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 01/632 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе

шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, СТОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Иргэний нисэхийн ерөнхий газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Иргэний нисэхийн ерөнхий газрын эрхэм зорилго нь Иргэний нисэхийн болон нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалт хийх, нислэгийн хөдөлгөөний удирдлага, холбоо, навигацийн техник тоног төхөөрөмж, мэдээлэл хангалт, нисэх буудал, газрын тусгай үйлчилгээ үзүүлж, үндэсний эдийн засагт хувь нэмэр оруулахад оршино.

Иргэний нисэхийн тухай хуулиар олгогдсон эрхийн дагуу, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн хувьд төрөөс Иргэний нисэхийн талаар зайлшгүй хэрэгжүүлэх дараах чиг үүрэг, үйлчилгээг хэрэгжүүлэн ажилладаг. Үүнд:

- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэх чиглэлээр тусгагдсан асуудлыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах;
- Иргэний нисэхийн талаарх Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллах;
- Агаарын хөлөгт нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээ үзүүлэх;
- Агаарын хөлгийн нислэгт холбоо навигацийн хангалт үйлчилгээ үзүүлэх;
- Нисэх буудлын газрын тусгай үйлчилгээ үзүүлэх;
- Иргэний нисэхийн салбарт нисэхийн болон нислэгийн аюулгүй байдлыг хангасан үйлчилгээ үзүүлэх;
- Мэргэжлийн туслалцаа үзүүлэх, мэргэжлийн сургалтыг зохион байгуулах;
- Төрийн захиргааны төв байгууллагаас шилжүүлсэн эрхийг хэрэгжүүлэх;
- Иргэний агаарын хөлгийг улсын бүртгэлд бүртгэх, бүртгэлийн гэрчилгээ олгох;
- Иргэний нисэхэд дагаж мөрдөх стандарт, заавар, зөвлөмж, боловсруулах, хэрэгжилтийг хангах зэрэг үндсэн үүргүүдийг хэрэгжүүлдэг байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Иргэний нисэхийн ерөнхий газрын агентлагийн урсгал зардлыг улсын төсвөөс, Үйлдвэрлэлийн алба, Нисэх хөдөлгөөн үйлчилгээний албадын зардлыг Зам, тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар баталж, навигацийн орлогоор санхүүжүүлдэг байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль



- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын тухай хууль
- Улсын нисэхийн тухай хууль
- Иргэний нисэхийн тухай хууль
- Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль болон бусад холбогдолтой хууль, эрхзүйн актын дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Иргэний нисэхийн ерөнхий газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд аудитад мэдээллийн технологийн мэргэжилтэн татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Иргэний нисэхийн ерөнхий газар санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Интерактив ХХК-ийн Веритех” програм хангамж ашигладаг байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын үндсэн үйл ажиллагаа, дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ. Дотоод хяналтын талаар доорх заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын тушаалаар баталсан дотоод аудит, хяналт шалгалт хийх хуваарийн дагуу ерөнхий газрын болон түүний харьяа 22 алба, салбар, хэлтэс нэгжид төлөвлөгөөт шалгалт 25, төлөвлөгөөт бус шалгалт 9 нийт 34 хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэсэн байна. Дээрх дотоод аудитын шалгалтаар илэрсэн алдаа, зөрчилд 192 зөвлөмж өгч хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан ба зөвлөмжийн хэрэгжилт 85 хувьтай үнэлэгдсэн байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Иргэний нисэхийн ерөнхий газрын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгө 793,044.2 сая төгрөгийг сонгов.

Энэ нь тайлант онд хөрөнгийн дахин үнэлгээ хийж үр дүнг санхүүгийн тайланд тусгасантай холбоотойгоор өмнөх оноос нийт хөрөнгө 2.6 дахин өссөнийг харгалзан 2018 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийг материаллаг байдлын сууриар сонгосон.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшинг Иргэний нисэхийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгө 793,044.2 сая төгрөгийн 1 хувь болох 7,930.4 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлээр төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшинг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд эрхлэх асуудлын хүрээний 20 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 14 байгууллага аудитад хамрагдсан байна. Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Үүнээс: Гэрээгээр хийлгэсэн	Аудитын түүвэрт хамрагдсан	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	1		3		
2	ТӨААН	13		3		
<b>Дүн</b>		<b>14</b>		<b>6</b>		

Аудитаар 14 санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргасан бөгөөд 1 ТӨААН-ийн санхүүгийн тайланд хараат бус аудитын компани гэрээгээр аудит хийсэн.

### 2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 22,442.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 74.7 хувь буюу 16,754.9 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 0.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 11.3 хувь буюу 2,554.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 14.0 хувь буюу 3,132.6 сая төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүллээ.

Аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 4.2 сая, төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд 13,557.8 сая төгрөгийн алдааг залруулсан бөгөөд төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн нэгтгэлээр 3,192.9 сая төгрөгийн алдааг залруулж баталгаажуулав. Үүнд:



- ✚ Тайлант онд ногдол ашигт төлсөн мөнгө, хуримтлагдсан ашгаас санхүүжүүлсэн зардал нийт 2,717.4 сая төгрөгөөр өмнөх оны үр дүнг буруулан бичсэн байна.
- ✚ Засгийн газрын 2017 оны 322, 2018 оны 150 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 01/6233 дугаар албан бичгийг үндэслэн Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төслийг хэрэгжүүлэх хамтарсан хуулийн этгээдийн монголын талд ногдох хувьд хөрөнгө оруулах 30,100.0 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлсэн ба уг санхүүжилтийг бүртгэл тайлагналд хэрхэн тусгах шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагаас тодруулахтай холбоотой асуудал тодорхой бус байснаас санхүүгийн тайлан хүргүүлэх хуулийн хугацаанд орлогын албан татварыг тооцоолох боломжгүй болж татварын зардлыг 209.3 сая төгрөгөөр дутуу тооцоолсноос авлага дутуу илэрхийлэгдсэн байна.
- ✚ Баян-Өлгий, Ховд аймгийн нисэх буудлууд дахин үнэлгээний тооцооллыг алдаатай хийж санхүүгийн тайланг нэгтгүүлсэн байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв. Үүнд:

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Үүнээс:							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТШЗ	1	25.6				-	1	25.6		
2	ТӨААН	19	955.8	1	0.7	3	114.0	15	841.1		
3	ТТЗ	6	4,706.1			4	2,440.2	2	2,265.9	2	
<b>Дүн</b>		<b>26</b>	<b>5,687.5</b>	<b>1</b>	<b>0.7</b>	<b>7</b>	<b>2,554.2</b>	<b>18</b>	<b>3,132.6</b>	<b>2</b>	

### 2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн материаллаг хэмжээний, анхаарал татахуйц алдаа, зөрчилтэй дараах асуудал байна. Үүнд:

- ✚ Шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны нөхөн олговор болон цалингийн маргаантай холбоотойгоор Чингис хаан Олон улсын нисэх онгоцны буудал ТӨҮГ 73.5 сая, Газрын тусгай үйлчилгээний алба 16.6 сая нийт 90.1 сая төгрөгийг зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2-д "төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх;" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүйд Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэн ажиллах, албан шаардлага,
- ✚ Олон улсын шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх захиргааны санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгахад 9.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материал дансанд бүртгэсэн, түрээсийн орлого 12.7 сая төгрөгийг аккурэл сууриар бүртгээгүй, 2.9 сая төгрөгийн цахилгааны төлбөрт тооцоо нийлсэн акт байхгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй зэрэг нийт 24.6 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн байна.

### **2.8.3 Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

#### **2.8.3.1 Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

##### Асуудал 1:

Жилийн эцсийн тооллогоор харьяа газруудад бараа материал 2.2 сая төгрөг, үндсэн хөрөнгө 22.0 сая төгрөг нийт 24.2 сая төгрөгийн хөрөнгө дутагдсан байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1-д "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах;" мөн хуулийн 67 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

##### Эрсдэл:

Үнэн зөв, тохиолдсон байх батламж мэдэгдэл хангагдахгүй байх, үндсэн хөрөнгөд бүртгэлээр тавих дотоод хяналт сул байх, хууль, дүрэм журам мөрдөгдөхгүй байх

##### Шийдэл:

Салбарын хэмжээнд үндсэн хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах, дутагдсан хөрөнгийг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх, албан шаардлага өгөх

#### **2.8.3.2 Авлагын данстай холбоотой асуудал**

##### Асуудал 1:

Гадаадын дампуурсан авиа компаниас авах, 1998-2017 онд үүссэн хугацаа хэтэрсэн тооцоо нийлсэн актгүй 2,300.3 сая төгрөгийн авлага санхүүгийн тайланд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ". заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

##### Эрсдэл:

Эрх ба үүрэг, үнэн зөв байх батламж мэдэгдэл хангагдаагүй, найдваргүй эзэн холбогдогчгүй авлага ихсэх, хууль, дүрэм, журам мөрдөгдөхгүй байх

##### Шийдэл:

Авлага өр, төлбөрийг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах, албан шаардлага өгөх

### **2.8.3.3 Зардлын данстай холбоотой асуудал**

#### **Асуудал:**

Сургуулиас хасагдаж гэрээ цуцлагдсан 3 оюутантай холбоотой 115.7 сая авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

#### **Эрсдэл:**

Эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдаагүй, үргүй зардал гарч авлага ихсэх

#### **Шийдэл:**

Гэрээний үүргээ биелүүлээгүйгээс буцаан төлүүлэхээр авлагаар тусгасан сургалтын төлбөрийг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах, албан шаардлага өгөх

### **2.8.3.3 Дуусаагүй барилга данстай холбоотой асуудал**

#### **Асуудал 3:**

✚ Үүрэг трейд ХХК-тай 2018 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр "Бүсийн нислэгийн хөдөлгөөний төвийн барилгын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх" 4,399.9 сая төгрөгийн гэрээг байгуулсан ба гэрээт ажлыг 2018 оны 12 дугаар сарын 20-нд багтаан дуусгахаар тусгасан байна. Тайлант онд гэрээний дүнгийн 84.0 хувь буюу 3,693.9 сая төгрөгийн санхүүжилтийг /1,320.0 сая төгрөгийг банкны баталгаагаар/ өгч авлагаар бүртгэжээ. Барилгын ажлын 3 удаагийн гүйцэтгэлийн баримтаар 2018 оны эцэст 59.6 хувь буюу 2,621.9 сая төгрөг байгаа ба гэрээнд заасан хугацаанд ажлаа дуусаагүй байна.

✚ Хурдны зам ХХК-тай 2018 оны 5 дугаар сарын 30-ны өдөр Завхан аймгийн Доной нисэх буудлын онгоц хөөрч, буух хатуу хучилттай зурвас, үерийн далан барих ажлын гэрээний үргэлжлэл, нэмэлт өөрчлөлтөөр 2018 оны 10 дугаар сарын 30-нд ашиглалтад оруулахаар 1,893.7 сая төгрөгийн гэрээ байгуулж нийт 52.0 хувь буюу 1,000.0 сая төгрөгийн санхүүжилт өгч авлагаар бүртгэсэн ба ажлын гүйцэтгэлийн баримтаар 2018 оны эцэст 69.0 хувь буюу 1,306.1 сая төгрөг гарч гэрээнд заасан хугацаанд ажил дуусаагүй байна.

#### **Эрсдэл:**

Эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдахгүй байх, хөрөнгө оруулалтын ажлын гэрээний үүргийн биелэлт хангуулах, дуусаагүй барилга болон авлагын дансанд тавих дотоод хяналт хууль, дүрэм, журам, гэрээний эрх үүрэг мөрдөгдөхгүй байх

#### **Шийдэл:**

Хөрөнгө оруулалтын ажлын гэрээний үүргийн биелэлтийг хангуулах, ажлын гүйцэтгэлийг гэрээнд заасан хугацаа болон өгсөн санхүүжилтээр нь хүлээж авч байх, ажлыг дуусгаж хүлээн авах талаар арга хэмжээ авч ажиллах албан шаардлага өгөх

## **2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Иргэний нисэхийн ерөнхий газрын дараагийн тайлангийн аудитаар хойшлогдсон татварын хөрөнгө өр, төлбөр, авлага өглөгийг барагдуулалт, дуусаагүй барилга дансыг авч үзэж анхаарал хандуулна.

## **2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Иргэний нисэхийн ерөнхий газар чиг, үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор 2018 онд үйл ажиллагааны орлогыг Зам, тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2018

оны 270/274 дугаар тушаалаар 316,769.1 сая төгрөгөөр батлагдснаас гүйцэтгэлээр 322,328.7 сая төгрөг буюу 101.8 хувийн биелэлттэй, үүнээс улсын төсөвт төвлөрүүлэх навигацийн орлогыг 167,672.8 сая төгрөгөөр баталж 100 хувь төвлөрүүлэн ажилласан байна.

Харин урсгал зардлыг 118,282.7 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардлыг 30,813.5 сая төгрөг нийт 149,096.3 сая төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 133,218.3 сая төгрөг буюу 89.3 хувийн биелэлттэй байна. Урсгал зардлын төсвөөс хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг байгууллагын даргын тушаалаар 14,288.9 сая төгрөгийн төлөвлөгөө батлагдаж 9,045.7 сая төгрөг буюу 63.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Мөн улсын төсвөөс агентлагийн урсгал зардалд 3,150.7 сая төгрөг батлагдаж 3,150.2 сая төгрөгийн буюу 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

## **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж цахим хуудсандаа шилэн данс цэсээр дамжуулан “shilendans.gov.mn” цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна.

- Дараа жилийн төсвийн төсөл /Бүтэн жилээр/
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт /Хагас, бүтэн жилээр, сар улирал бүр/
- Тухайн жилийн төсөв орсон нэмэлт, өөрчлөлт /Тухай бүр/
- Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан /Хагас, бүтэн жилээр/
- Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан /Хагас, бүтэн жилээр/
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ /Тухай бүр/
- Санхүүгийн тайлан /Хагас, бүтэн жилээр/
- Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт /Бүтэн жилээр/
- Байгууллагын батлагдсан төсөв /Бүтэн жилээр/

## **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 1,132.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 5 зөвлөмж, 3,775.9 сая төгрөгийн 3 албан шаардлага, 908.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон ба 2018 оны жилийн эцсийн байдлаар биелэлт 92.0 хувьтай үнэлэгдсэн үндсэн хөрөнгө дутагдсантай холбоотой зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүйд албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн болно.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Иргэний нисэхийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3 Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Иргэний нисэхийн ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Дуусаагүй барилга данстай холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч 9 байгууллага, аж ахуйн нэгжтэй холбоотой гэрээний үүргээ биелүүлээгүй, гэрээний хугацаа дууссан, ажил дүгнэсэн болон хүлээн авсан актгүй дуусаагүй барилга дансанд бүртгэсэн 1,287.5 сая төгрөгийн үлдэгдэл байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна

##### **3.1.2 Эрсдэл:**

Үнэн зөв, тодруулга ба толилуулга батламж мэдэгдэл хангагдахгүй байх, санхүүгийн тайланд бүртгэлээр тавих хяналт сулрах, дуусаагүй барилга дансны үлдэгдэл ихсэх

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй хөрөнгө оруулалтын ажлуудыг дуусгах, гэрээг дүгнэн хүлээн авах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана

#### **3.2 Зардлын данстай холбоотой асуудал**

##### **3.2.1 Илрүүлэлт:**

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагуудын 20 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн ба үүнээс 13 санхүүгийн тайланд зөрчилгүй, 1 санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн, 6 санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан. Аудитаар нийт 14,543.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 13,562.9 сая төгрөгийн алдааг залруулж 0.7 сая төгрөгийн акт тогтоож, 114.0 сая төгрөгийн албан шаардлага, 866.7 сая төгрөгийн зөвлөмж өгсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдаагүй, дээд шатны удирдлагын дотоод хяналт сул байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Харьяа газруудад өгсөн зөвлөмж, албан шаардлага, актын биелэлтийг хэрэгжүүлэн ажиллахад хяналт тавих, зөрчлийг давтан гаргуулахгүй байхад анхаарч ажиллах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 9 дүгээр сарын 01-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



#### 4 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	121,059,673.6	137,631,828.2
Мөнгөн хөрөнгө	66,063,760.3	71,070,610.9
Авлага	46,055,032.2	56,588,520.6
Урьдчилж төлсөн зардал	1,399,603.4	2,032,074.9
Бараа материал	7,535,730.2	7,935,074.3
Бусад эргэлтийн хөрөнгө	5,547.5	5,547.5
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	179,915,815.7	655,887,944.6
УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	179,915,815.7	655,887,944.6
Биет хөрөнгө	155,960,121.2	170,670,864.9
Биет бус хөрөнгө	1,686,662.1	463,903,795.7
Хойшлогдсон татварын хөрөнгө	571,198.8	375,570.8
Дуусаагүй барилга	21,697,833.6	20,937,713.2
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>300,975,489.2</b>	<b>793,519,772.8</b>
НИЙТ ӨР ТӨЛБӨР	9,433,445.5	12,814,005.2
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,065,796.1	3,689,386.5
Өглөг	6,012,883.9	3,659,026.3
Урьдчилж орсон орлого	52,912.1	30,360.2
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,367,649.4	9,124,618.7
Урьдчилж орсон орлого /ХО/	3,367,649.4	9,124,618.7
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	291,542,043.8	780,705,767.6
Засгийн газрын хувь оролцоо	291,542,043.8	780,705,767.6
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	225,569,216.1	688,539,206.9
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	3,137,401.9	33,224,636.6
Хуримтлагдсан үр дүн	62,835,425.8	58,941,924.1
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>300,975,489.2</b>	<b>793,519,772.8</b>

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	281,692,293.5	316,666,404.2
ТАТВАРЫН ОРЛОГО		
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	281,692,293.5	316,666,404.2
Нийтлэг татварын бус орлого	281,692,293.5	316,666,404.2
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	247,623,183.3	276,438,505.1
УРСГАЛ ЗАРДАЛ	247,623,183.3	276,438,505.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	100,018,267.3	108,765,705.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	55,039,112.2	60,781,433.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,242,685.5	7,563,171.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,283,645.1	6,076,262.7
Хангамж, бараа материалын зардал	1,423,694.6	6,044,275.2
Эд хогшил, урсгал засварын зардал	3,925,401.8	3,354,782.6
Томилолт, зочны зардал	796,175.3	989,191.1
Бараа үйлчилгээний бусад зардал	25,307,552.8	23,956,589.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	147,604,916.0	167,672,800.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	34,069,110.2	40,227,899.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	8,236,811.0	13,984,270.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	15,620,274.1	53,303,463.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	26,685,647.0	908,705.8
Орлогын татварын зардал	5,678,371.2	2,084,853.6
Тайлант үеийн үр дүн	21,007,275.8	(1,176,147.8)

### 4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	277,709,709.5	394,042,866.8
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	277,709,709.5	394,042,866.8
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	-
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	251,589,153.5	366,810,097.1
УРСГАЛ ЗАРДАЛ	251,589,153.5	366,810,097.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	251,589,153.5	366,810,097.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	51,450,665.0	56,874,738.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,853,970.9	13,244,584.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,446,483.2	6,923,287.6
Хангамж, бараа материалын зардал	5,571,777.7	7,077,184.1
Эд хогшил, урсгал засварын зардал	3,750,142.8	5,011,465.8
Бараа үйлчилгээний бусад зардал	173,516,114.0	277,678,836.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	26,120,555.9	27,232,769.7
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	1,698,725.2	2,877,535.9
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	6,551,185.0	9,584,801.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	0.00
Дотоод эх үүсвэрээр	6,551,185.0	9,584,801.3
Гадаад эх үүсвэрээр	0.00	0.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(4,852,459.9)	(6,707,265.4)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	15,518,653.7
Бусад эх үүсвэр	0.00	55,229.3
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.00	0.00
ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	0.00	0.00
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.00	15,573,883.0
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	21,268,096.1	5,006,850.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	44,795,664.2	66,063,760.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	66,063,760.3	71,070,610.9

#### 4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>271,496,414.7</b>		<b>271,496,414.7</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(4,099,048.6)		(4,099,048.6)
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>267,397,366.1</b>		<b>267,397,366.1</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт			
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт			
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			
Эздийн өмчийн бусад хэсэг	3,137,401.9		3,137,401.9
Тайлант үеийн үр дүн	21,007,275.8		21,007,275.8
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>291,542,043.8</b>		<b>291,542,043.8</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>291,542,043.8</b>		<b>291,542,043.8</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	30,234,546.2		30,234,546.2
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	462,969,990.8		462,969,990.8
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	(2,717,353.9)		(2,717,353.9)
Эздийн өмчийн бусад хэсэг	2,990,090.4		2,990,090.4
Тайлант үеийн үр дүн	(1,176,147.8)		(1,176,147.8)
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>780,705,767.6</b>		<b>780,705,767.6</b>

**Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо:	<b>2019.03.25</b>	Аудитын нэр:	<b>2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудит</b>	Аудитын код:	<b>САГ-2019/14/СТА-ТТЗ</b>
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Иргэний нисэхийн ерөнхий газар</b>			Сая төгрөг	

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллаг аас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
		Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5
Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч 9 байгууллага, аж ахуйн нэгжтэй холбоотой гэрээний үүргээ биелүүлээгүй, гэрээний хугацаа дууссан, ажил дүгнэсэн болон хүлээн авсан актгүй дуусаагүй барилга дансанд бүртгэсэн 1,287.5 сая төгрөгийн үлдэгдэл байна.	1,287.5	Зөвлөмж	Нягтлан бодогч	Б.Үүрцайх
Гадаадын дампуурсан авиа компаниас авах, хугацаа хэтэрсэн 1998-2017 онд үүссэн, тооцоо нийлсэн актгүй 2,300.3 сая төгрөгийн авлага санхүүгийн тайланд бүртгэлтэй байна.	2,300.3	Албан шаардлага	Нягтлан бодогч	Г.Амарзаяа
Сургуулиас хасагдаж гэрээ цуцлагдсан 3 оюутантай холбоотой 115.7 сая авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	115.7	Албан шаардлага	Нягтлан бодогч	Т.Энхтуяа
Жилийн эцсийн тооллогоор харьяа газруудад бараа материал 2.2 сая төгрөг, үндсэн хөрөнгө 22.0 сая төгрөг нийт 24.2 сая төгрөгийн хөрөнгө дутагдсан байна.	24.2	Албан шаардлага		
Үүрэг трейд ХХК-тай 2018 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр "Бүсийн нислэгийн хөдөлгөөний төвийн барилгын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх" 4,399.9 сая төгрөгийн гэрээг байгуулсан ба гэрээт ажлыг 2018 оны 12 дугаар сарын 20-нд багтаан дуусгахаар тусгасан байна. Тайлант онд гэрээний дүнгийн 84.0 хувь буюу 3,693.9 сая төгрөгийн санхүүжилтийг /1,320.0 сая төгрөгийг банкны баталгаагаар/ өгч авлагаар бүртгэжээ. Барилгын ажлын 3 удаагийн гүйцэтгэлийн баримтаар 2018 оны эцэст 59.6 хувь буюу 2,621.9 сая төгрөг байгаа ба гэрээнд заасан хугацаанд ажлаа дуусаагүй байна.		Албан шаардлага	ЗТХЯ-ны ТНБ-ийн дарга	Ж.Бат-Эрдэнэ
			ИНЕГ-ын дарга	Л.Бямбасүрэн
			ИНЕГ-ын санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга	Ч.Нямсүрэн
			Агаарын навигацийн бодлого зохицуулалтын хэлтсийн дарга	Ё.Эрдэнэбат
			Хууль эрх зүй, дүрмийн боловсруулалтын газрын дарга	П.Ариунболд
Хурдны зам ХХК-тай 2018 оны 5 дугаар сарын 30-ны өдөр Завхан аймгийн Доной нисэх буудлын онгоц хөөрч, буух хатуу хучилттай зурвас, үерийн далан барих ажлын гэрээний үргэлжлэл, нэмэлт өөрчлөлтөөр 2018 оны 10 дугаар сарын 30-нд ашиглалтад оруулахаар 1,893.7 сая төгрөгийн гэрээ байгуулж нийт 52.0 хувь буюу 1,000.0 сая			ЗТХЯ-ны ТНБ-ийн дарга	Ж.Бат-Эрдэнэ
			ИНЕГ-ын дарга	Л.Бямбасүрэн
			ИНЕГ-ын тэргүүн дэд дарга	Б.Алтанцом

**Иргэний нисэхийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<p>төгрөгийн санхүүжилт өгч авлагаар бүртгэсэн ба ажлын гүйцэтгэлийн баримтаар 2018 оны эцэст 69.0 хувь буюу 1,306.1 сая төгрөг гарч гэрээнд заасан хугацаанд ажил дуусаагүй байна.</p>		<p>Албан шаардлага</p>	<p>ИНЕГ-ын захиргаа удирдлагын газрын дарга</p>	<p>Т.Батжаргал</p>
			<p>ИНЕГ-ын санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга</p>	<p>Ч.Нямсүрэн</p>
			<p>Худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга</p>	<p>Б.Батхишиг</p>
			<p>Агаарын навигацийн бодлого зохицуулалтын хэлтсийн дарга</p>	<p>Ё.Эрдэнэбат</p>
			<p>Захиргаа, удирдлагын газрын мэргэжилтэн</p>	<p>Б.Мөнхбат</p>
<p>Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагуудын 20 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн ба үүнээс 13 санхүүгийн тайланд зөрчилгүй, 1 санхүүгийн тайланд итгэл үзүүлж, 6 санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулсан. Аудитаар нийт 14,543.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 13,562.0 сая төгрөгийн алдааг залруулж 0.7 сая төгрөгийн акт тогтоож, 114.0 сая төгрөгийн албан шаардлага, 866.7 сая төгрөгийн зөвлөмж өгсөн байна.</p>	<p>978.4</p>	<p>Зөвлөмж</p>	<p>Харьяа алба, салбаруудын дарга, нягтлан</p>	
<p><b>Нийт дүн</b></p>	<p><b>4,706.1</b></p>			